



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 4 (337)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Онцгой албан татварын хуульд нэмэлт оруулах тухай*
- *Төрийн нууцын жагсаалт батлах тухай*
- *Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны нэгдүгээр сарын 20 № 4 (337)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |     |  |                      |    |
|-----|--|----------------------|----|
| 33. | Онцгой албан татварын хуульд нэмэлт оруулах тухай  | (2004-1-2-ны хууль)  | 30 |
| 34. | Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын Сайд нарын Танхим хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай                    | (2004-1-2-ны хууль)  | 30 |
| 35. | Төрийн нууцын жагсаалт батлах тухай  | (2004-1-2-ны хууль)  | 31 |
| 36. | Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай  | (2004-1-2-ны хууль)  | 40 |
| 37. | Төрийн нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  | (2004-1-2-ны хууль)  | 41 |
| 38. | Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай   | (2004-1-2-ны хууль)  | 41 |
| 39. | Засаглалын шинэчлэлийн хөтөлбөрийн хоёр дахь шатны зээлийн гэрээ болон засаглалын шинэчлэлийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны зээлийн гэрээг соёрхон батлах тухай | (2004-1-8-ны хууль)  | 42 |
| 40. | "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын болон ОХУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрийг соёрхон батлах тухай                            | (2004-1-8-ны хууль)  | 42 |
| 41. | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  | (2004-1-9-ний хууль) | 42 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |     |  |           |    |
|-----|--|-----------|----|
| 42. | Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 01 | 43 |
|-----|--|-----------|----|



43.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журмыг батлах тухай	Дугаар 02	43
44.	Зарим тусгай хамгаалалттай газрын хилийн заагийг өөрчлөх тухай тогтоолын төслийг буцаах тухай	Дугаар 03	47
45.	Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох тухай	Дугаар 04	47
46.	Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 05	47
47.	Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай	Дугаар 06	48
48.	2004 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 07	48

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлд дараахь хэсэг нэмсүгэй: үйлдвэрлэхэд түүхий эдийн зориулалтаар импортолсон задгай тамхинд ногдуулсан онцгой албан татварын дүнг хэсч тооцно."

"6 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

МОНГОЛ УЛСЫН ИХ

7. Эх орны үйлдвэрийн янжуур тамхинд онцгой албан татвар ногдуулахдаа уг тамхийг

ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, УКРАИН УЛСЫН САЙД НАРЫН ТАНХИМ ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улаанбаатар хотноо 2003 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын Сайд нарын

Танхим хоорондын Хэлэлцээрийг Засгийн газрын ергөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ

ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр  
сарын 2-ны өдөрУлаанбаатар  
хот

### ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дор дурдсан мэдээ, баримт Улсын төрийн нууцад хамааруулна:

бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг Монгол

д/д	Төрийн нууцын жагсаалт	Нууцын зэрэглэл			Нууцлах хугацаа (жилээр)
		онц чухал маш нууц	маш нууц	нууц	
0	A	1	2	3	4

Нэг.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээнд:

1	Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлол, улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалтай холбоотой, энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан бөгөөд төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар хэрэглэж нууцалсан мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	нууцалсан зэрэглэлээр			байнга
2	Улсын Их Хурлын чуулган, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн, энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан бөгөөд төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар хэрэглэж нууцалсан мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	нууцалсан зэрэглэлээр			байнга



3	Аливаа улс оронтой харилцах Монгол Улсын чиг бодлого, байр суурийг нарийвчлан илэрхийлсэн баримт бичиг, гадаад орнуудаас итгэмжлэгдсэн байдлаар авсан бүх төрлийн мэдээ, мэдээлэл	нууцалсан зэрэглэлээр	байнга
4	Гадаад орон, олон улсын байгууллагатай Монгол Улсын Засгийн газар, Төв банк санхүүгийн салбарт хамтран ажиллах болон өр, зээл, тусламжтай холбоотой гэрээ хэлэлцээрийн төсөл, тэдгээрийн боловсруулалтын шатанд хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	нууцалсан зэрэглэлээр	тусгайлан заагаагүй бол хүчин төгөлдөр болтол
5	Төрийн дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, хоёр болон олон талын яриа, хэлэлцээний сэдэв, илтгэл, тэмдэглэл, тэдгээрт холбогдох баримт бичиг	нууцалсан зэрэглэлээр	талууд өөрөөр тохироогүй бол хэлэлцээр дуустал
6	Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи, гүйцэтгэх ажлын болон бусад хүрээний нууцалбал зохих асуудлаар гадаад орны Засгийн газар, байгууллагатай байгуулсан хоёр талын болон олон улсын гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн төсөл, хэрэгжилтийн талаархи мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	нууцалсан зэрэглэлээр	талууд өөрөөр тохироогүй бол 60
7	Хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын ажлын удирдамж, төлөвлөгөө	нууцалсан зэрэглэлээр	10



8	Онц байдалд хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын ажиллах төлөвлөгөө	нууцалсан зэрэглэлээр	10
9	Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи, гүйцэтгэх ажлын болон бусад хүрээний нууцалвал зохих асуудлаар олон улсын хурал зөвлөлгөөн, чуулганд оролцох төлөөлөгчдийн ажлын чиглэл, удирдамж	нууцалсан зэрэглэлээр	10
10	Энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйлийг битүүмжлэн хүргэх төрийн тусгай болон дипломат шуудан: 1/ битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэл 2/ бүртгэл нь	нууцалсан зэрэглэлээр	байнга
			+
			10
11	Улсын онц чухал болон тусгай объектын байршил, олгосон газрын нэр, зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	+	40
12	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн болон хурал, чуулган, арга хэмжээ, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн байнгын болон цаг үеийн хамгаалалтыг зохион байгуулахтай холбоотой мэдээ, баримт бичиг	+	10



13	Төрийн шифр харилцааны бодлого, төрийн тусгай хэрэглээний мэдээлэл холбооны болон шифрийн криптографын боловсруулалт, сан, нөөц, шифрийн арга ажиллагаа, аргачлал, тэдгээрийг ашиглах заавар, код, түлхүүр, түүнд холбогдох баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	+		байнга
14	Төрийн шифр харилцааны дүрэм, заавар, шифрийн материалын нэгдсэн бүртгэл		+	60
15	Төрийн шифр мэдээ	нууцалсан зэрэглэлээр		60
16	Төрийн мэдээлэл холбооны систем, сүлжээ, түүний бүтэц, зохион байгуулалт, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, программ хангамж, код, түлхүүрийн баримт бичиг, техникийн өгөгдөхүүн, ашиглалт, үйлчилгээний заавар, техникийн баримт бичиг, радио долгионы давтамжийн хуваарилалт, тэдгээрт холбогдох баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа		+	60
17	Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сан		+	байнга
18	Энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан, устгасан тухай мэдээ, баримт бичиг		+	60
19	Энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйл, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгаж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд холбогдох баримт бичиг, эд зүйл	нууцалсан зэрэглэлээр		25



## Хоёр. Батлан хамгаалах хүрээнд:

20	Төрийн цэргийн бодлогын нууцалбал зохих хэсэг, заалт, зэвсэгт хүчнийг ашиглах номлол	нууцалсан зэрэглэлээр			40
21	Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын байлдааны цагийн орон тоо, жинхэнэ нэр, зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт	+			40
22	Зэвсэгт хүчний стратегийн удирдамж, бэлэн байдлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлтийн мэдээ, тооцоо, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, ашиглах, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, байлдаанд бэлтгэх, шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах арга ажиллагааны тактик, тэдгээрт холбогдох мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа		+		40
23	Байлдааны бэлэн байдлын мэдээ, байлдааны тушаал, захирамж, байлдааны ажиллагааны газар, орныг төхөөрөмжлөхтэй холбогдсон мэдээ, баримт бичиг, энэ хуулийн 20-31дүгээр зүйлд заагдсан баримтыг тусгасан байр зүйн зураг	нууцалсан зэрэглэлээр			40
24	Зэвсэгт хүчний дайчилгааны даалгавар, нөөц, нөхөн хангах тооцоо, байлдааны техник зэвсэглэл, материал, галт хэрэгслийн хангалт, захиалга, нөөцийн тооцоо, мэдээ		+		20
25	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээ, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо				





	1. Улсын хэмжээнд		+		15
	2. Нийслэл, аймгийн хэмжээнд			+	10
26	Зэвсэгт хүчний автоматжуулсан болон далдуур удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалт, хангалт, тэдгээрт холбогдох мэдээ, баримт бичиг		+		40
27	Зэвсэгт хүчний удирдлагын байрны байршил, мэдээлэл, холбооны сүлжээ, радио долгионы давтамжийн хуваарилалт, баримт бичиг	нууцалсан зэрэглэлээр			50
28	Цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр, дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, түүнтэй холбоотой баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа				
	1. Улсын хэмжээнд		+		40
	2. Аймаг, нийслэлийн хэмжээнд			+	20
29	Улсын хил хамгаалалт, хангалтын зохион байгуулалт, арга ажиллагаа, оператив төлөвлөгөө, зэвсэглэл, материал техникийн нэгдсэн захиалга, тооцоо, мэдээ, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулж явуулахтай холбогдсон баримт бичиг		+		40
30	Улсын болон дайчилгааны стратегийн нөөцийн бодит хэмжээ, байршил, тэдгээрийн тайлан, мэдээ, санхүүжилттэй холбогдсон баримт бичиг	+			40
31	Улсын болон дайчилгааны нөөцийн жилийн болон дунд, урт хугацааны үндсэн чиглэлийн төслийн тооцоо, үндэслэл, түүнийг хэрэгжүүлэх талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг		+		40



32	1:100000-аас илүү нарийвчлалтай масштабын байр зүйн зураг	нууцалсан зэрэглэлээр			байнга
33	Иргэний хамгаалалтын оператив болон онцгой үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглахтай хобогдсон баримт бичиг, удирдлагын хоргодох байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээлэл, биет зүйл	нууцалсан зэрэглэлээр			20
Гурав. Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд:					
34	Улсын эрдэнэсийн сан, мөнгөн тэмдэгтийн нөөцтэй холбогдсон болон нөөцийн сангийн байршил, тэдгээрийн хамгаалалттай холбогдох мэдээ, баримт бичиг		+		байнга
35	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажлын төсвийн дэлгэрэнгүй үзүүлэлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан		+		20
36	Бэлэн мөнгө хэвлэх, устгах болон алт, эрдэнэсийн зүйл, бэлэн мөнгө тээвэрлэх зам, цаг хугацаа, хамгаалах хүч, хэрэгслийн тухай мэдээ, баримт бичиг		+		5
37	Шинжлэх ухаан, технологийн ололтыг дотоод, гадаадад дамжуулах лицензийн гэрээтэй холбоотой баримт бичиг	нууцалсан зэрэглэлээр			гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол 10
38	Энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын диссертаци, тайлан, дүгнэлт, онолын бага хурал, зөвлөлгөөн, лекц, хичээлийн тэмдэглэл, сургууль төгсөгчдийн дипломын ажил, тэдгээрт холбогдох баримт бичиг	нууцалсан зэрэглэлээр			15



## Дөрөв. Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд:

39	Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж, тэдгээрийг халхаачлахтай холбогдолтой мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	+			байнга
40	Гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлийн тайлан, мэдээ, судалгаа, тусгай сангийн баримт бичиг	+			байнга
41	Гүйцэтгэх ажлын мэдээллийн сан, түүнд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник технологи, программ хангамж, нууцлах код, түлхүүр, өгөгдөл, компьютерийн тоон мэдээлэл агуулах төхөөрөмж дэх нууцын зэрэглэл бүхий баримт бичиг			нууцалсан зэрэглэлээр	60
42	Бие бүрэлдэхүүнийг нь нууцалбал зохих гүйцэтгэх ажил, тагнуул, сөрөх тагнуулын байгууллагын салбар нэгж, тэдгээрийн байр, байршил, тээврийн хэрэгслийн улсын дугаар, гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл, тэдгээрт холбогдох мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа			+	60
43	Гүйцэтгэх ажлын шугамаар шалгасан болон шалгаж байгаа хэргийн баримт бичиг, холбогдох эд зүйл, үйл ажиллагаа			+	60
44	Эрх бүхий байгууллагын удирдлагаас гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гаргасан шийдвэр, заавар, журам, холбогдох баримт бичиг			+	60
45	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтнууд үйл ажиллагаандаа удирдамж болгох үндсэн төлөвлөгөө, тайлан, ажлын байрны тодорхойлолт, тэдгээрт холбогдох баримт бичиг			+	60



46	Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, гүйцэтгэх ажлын төсөв, зардал, тэдгээрт холбогдох баримт бичиг			+		60
47	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудын гүйцэтгэх ажилтны хувийн хэрэг, төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар, тэдний албан ажилтай холбогдсон мэдээ, баримт бичиг			+		60
48	Гүйцэтгэх ажлын эрдэм шинжилгээ, түүх судалгаа, сургалтын холбогдолтой бүтээл, ном, сэтгүүл, хичээлийн хөтөлбөр, тэдгээрт холбогдох баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа			+		60
49	Тагнуулын байгууллагаас үндэсний аюулгүй байдалтай холбогдуулан төр засгийн дээд болон эрх бүхий бусад байгууллагад илгээсэн мэдээ, илтгэх хуудас, танилцуулга				нууцалсан зэрэглэлээр	60
50	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын Тусгай архивын данс, бүртгэл, эд зүйл				нууцалсан зэрэглэлээр	60
51	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудын өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх төлөвлөгөө, онц, хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэг гарсан үед ажиллах төлөвлөгөө, удирдамж, хэрэглэх дохио			+		20
52	Гүйцэтгэх ажил болон төрийн тусгай хамгаалалтад ашиглаж байгаа радио долгионы давтамжийн хуваарилалт, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын телефон утасны жагсаалт			+		60



53	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа	нууцалсан зэрэглэлээр	30
----	---	-----------------------	----

Тав. Бусад

54	Төрийн нууцад хамаарах асуудлаар хэлэлцсэн төрийн байгууллагын хаалттай хуралдааны тэмдэглэл, түүнд холбогдох мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	нууцалсан зэрэглэлээр	20
55	Цаазаар авах ял гүйцэтгэх журам, ажиллагаа, гүйцэтгэсэн тухай баримт бичиг	+	байнга
56	Дайны болон дайн бүхий байдлын үед төрийн байгууллагын ажиллах төлөвлөгөө, холбогдох мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа	+	40
57	Улсын онц чухал болон тусгай объект, үйл ажиллагааг халхлах журам	+	50
58	Цэвэр ус олзворлон түгээх байгууламжийн байршлын зураг		байнга

Тайлбар: Нууцын зэрэглэлийг /+/ гэж тэмдэглэв.

МОНГОЛ УЛСЫН ИХ

ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурлаас 1995 оны 7 дугаар сарын 4-ний өдөр баталсан Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ

ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Харин гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж болон гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлд холбогдох мэдээ, баримт бичигтэй зөвхөн шалгаж байгаа асуудлын хүрээнд Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны дарга, гишүүнээс бусад хүн танилцахыг хориглоно." гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "10/ иргэний хамгаалалтын нийтийн дайчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх болон онцгой нөхцөл байдлын үед хүн амын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, хангалтын объектуудын байрлал, зориулалт, энэ үед дэд бүтцийг ашиглахтай холбогдсон мэдээлэл, биет зүйл." гэсэн 10 дахь заалт нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Төрийн нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан хүрээнд төрийн нууцад хамааруулах зүйлсийн жагсаалтыг хуулиар батална."

**4 дүгээр зүйл.** Төрийн нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "биет зүйлийг" гэснийг тус тус "эд зүйл, объект, үйл ажиллагааг" гэж; мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3 дахь заалт, 15 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Тагнуулын төв газар" гэснийг "Тагнуулын ерөнхий газар" гэж; мөн хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "хайх" гэснийг "хайж олох" гэж; мөн хэсгийн "тараахыг" гэснийг "задруулахыг" гэж; мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх заалтын "500-2500" гэснийг "25000-50000" гэж; мөн зүйлийн 2 дахь заалтын "1000-5000" гэснийг "10000-50000" гэж; мөн зүйлийн 3 дахь заалтын "5000-10000" гэснийг "15000-35000" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн "Улсын" гэснийг "Төрийн" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХОЁР ДАХЬ ШАТНЫ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БОЛОН ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТЕХНИК ТУСЛАЛЦААНЫ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд 2003 оны 12 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Засаглалын шинэчлэлийн хөтөлбөрийн хоёр дахь шатны зээлийн Гэрээ, Засаглалын шинэчлэлийн чадавхийг бэхжүүлэх

техник туслалцааны зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр тус тус соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ОХУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын болон ОХУ-ын Засгийн газрын хооронд 2003 оны 7 дугаар сарын

1-ний өдөр байгуулсан Хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

7.2.1.1. нийслэлд 95

1/5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:

7.2.1.2. аймгийн төвд 97

хувиар;

7.2.1.3. сумын төв, тосгонд

98 хувиар;

"5.2 Иргэнд өмчлүүлэх газарт үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтооно."

7.2.2. газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газар;

7.2.2.1. нийслэлд 30

2/7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:

хувиар;

7.2.2.2. аймгийн төвд 70

"7.2. Газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг дараахь байдлаар хөнгөлнө:

хувиар;

7.2.2.3. сумын төв, тосгонд

85 хувиар;

7.2.1. гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газар;

7.2.3. газар тариалангийн зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газрыг 95 хувиар;



3/8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг;

"8.4. Газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ногдуулж, татварын байцаагч хурааж, орон нутгийн төсөвт оруулна."

4/9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг;

"9.4. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага / албан тушаалтан / газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайланг нэгтгэж, нэг хувийг харъяалах татварын албанд дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тушаана."

**2 дугаар зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн "Үл хөдлөх" гэсний өмнө "Газраас бусад" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн гарчгийг "Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Үндэсний хөтөлбөр, Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1.Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих Үндэсний Зөвлөлийн гишүүнд "Хууль зүй, дотоод хэргийн сайд" гэж нэмсүгэй.

2."Зөвлөлийн нарийн бичгийн дарга: -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга" гэснийг "Зөвлөлийн нарийн бичгийн дарга орон тооны байна" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журмыг батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 80 дугаар тогтоолын 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**





Монгол Улсын Их Хурлын 2004 оны  
02 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД БАРИМТЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /цаашид—"Үндсэн чиглэл" гэж/ нь Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн стратеги, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн жилд төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичиг болно.

1.3. Энэхүү журмын биелэлтэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хяналт тавина.

### Хоёр. Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах хугацаа

2.1. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага Үндсэн чиглэлийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд боловсруулж, тухайн оны 9 дүгээр сарын 1-ний дотор санхүү эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

2.2. Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Үндсэн чиглэлийн төслийг хянан хүлээн авч, нэгтгэн боловсруулж, тухайн оны 9 дүгээр сарын 20-ны дотор Засгийн газрын хуралдаанд оруулна.

2.3. Засгийн газар Үндсэн чиглэлийн төслийг хэлэлцээд тухайн оны 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

### Гурав. Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг

3.1. Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэгтэй:

3.1.1. төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас үндсэн чиглэлийн төслийг боловсруулах нийтлэг загварыг Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.2. төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтот үзүүлэлтээр гаргах мэдээллийн маягт, зааврыг баталж, мөрдүүлэх;

3.1.3. Үндсэн чиглэлийн төслийг улс орны хөгжлийн стратеги, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, батлагдсан бусад хөтөлбөр, төсөл, улсын төсөв болон гадаадын зээл, тусламж, мөнгө санхүү, хөдөлмөрийн зах зээл, бизнесийн үйл ажиллагаатай уялдуулан боловсруулах.

### Дөрөв. Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад төрийн захиргааны төв байгууллагын үүрэг

4.1. Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэгтэй:

4.1.1. Үндсэн чиглэлийн төсөл болон салбарын хүрээний үндсэн үзүүлэлтүүдийг 3.1.1, 3.1.2-т заасан нийтлэг загвар, маягт, зааврын дагуу боловсруулан санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх;

4.1.2. салбарын шууд болон орон нутгийн харьяа газруудаас энэ журмын 3.1.2-т заасан маягт, зааврын дагуу мэдээлэл гаргуулан авч нэгтгэн боловсруулж үндсэн чиглэлийн төсөлд тусгах;

4.1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан болон тухайн салбарт шийдвэрлэх бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг бизнесийн үйл ажиллагаа, гадаад дотоод санхүүгийн эх үүсвэр, төсөв, хөрөнгө оруулалттай нягт уялдуулан боловсруулах.

4.2. Төрийн захиргааны төв байгууллага салбарын хэмжээнд Үндсэн чиглэлийн төсөл боловсруулах журам, заавар батлан мөрдүүлж болно.

### Тав. Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад нутгийн захиргааны байгууллагын үүрэг

5.1. Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад нутгийн захиргааны байгууллага дараах үүрэгтэй :

5.1.1. Үндсэн чиглэлийн төслийг энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан нийтлэг загвар, маягт зааврын дагуу тухайн бүс, аймаг, нийслэлийн бизнесийн үйл ажиллагаа, жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй нягт уялдуулан боловсруулж, тогтоосон хугацаанд санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх;

5.1.2. Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, стратеги, Засаг даргын мөрийн хөтөлбөрт заасан бодлого, арга хэмжээ, бүсийн болон орон нутгийн түвшинд шийдвэрлэх асуудлууд, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тухайн аймгийн оруулах хувь нэмрийг тооцсон байх;

5.1.3. энэхүү журмын 3.1.2-т заасан маягтад тусгасан үзүүлэлтүүдийг сум, дүүрэг, аж ахуйн нэгж байгууллагаас гаргуулан авах;

5.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд үндсэн чиглэл төсөл боловсруулах журам заавар гарган мөрдүүлж болно.

### Зургаа. Үндсэн чиглэлийн бүтэц, агуулга

6.1. Үндсэн чиглэл нь дараахь бүтэц, агуулгатай байна:

6.1.1. макро эдийн засгийн үндсэн тэнцвэр, тогтворжилттой холбоотой бодлого, чиглэл, арга хэмжээ, зарим тоон үзүүлэлтүүд:

6.1.1.1. эдийн засгийн өсөлтийн талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, бодит өсөлт;

6.1.1.2. ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, түүнийг бууруулах бодлого, арга хэмжээ;

6.1.1.3. төсвийн тогтвортой, тэнцвэрт байдлыг хангах бодлого, арга хэмжээ, төсвийн нийт болон урсгал тэнцэл, хөрөнгө оруулалт, татварын талаар баримтлах бодлого, арга хэмжээ;

6.1.1.4. мөнгө зээлийн бодлого, арга хэмжээ, тэдгээрийн макро эдийн засгийн харьцаа, үнэ ханшийг мөнгөний бодлогоор зохицуулах;

6.1.1.5. экспорт, импорт, гадаад худалдаа, хөрөнгийн урсгал, гадаад өр, зээл тусламж, төлбөрийн тэнцлийн талаарх бодлого, арга хэмжээ;

6.1.1.6 эдийн засгийн өсөлтийг дэмжсэн санхүүгийн зах зээлийн бодлого, арга хэмжээ, үнэт цаасны зах зээл, даатгал, банк, банк бус санхүүгийн байгууллага, бүртгэл, аудит.

6.1.2. эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, арга хэмжээ, зарим тоон үзүүлэлтүүд:

6.1.2.1 аж үйлдвэр, хөдөө аж ахуй, барилга, тээвэр холбоо, мэдээлэл, үйлчилгээний салбарын хөгжил;

6.1.2.2. шинжлэх ухаан, технологийн хөгжил.

6.1.2.3. шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүн.

6.1.3. бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, арга хэмжээ:

6.1.3.1. эдийн засгийн бүсүүдийг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ;

6.1.3.2. хөдөөгийн хөгжлийн бодлого, арга хэмжээ;

6.1.3.3. байгаль орчинг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлого, арга хэмжээ.

6.1.4. хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ:

6.1.4.1. боловсролыг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ;

6.1.4.2. эрүүл мэнд, биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ;

6.1.4.3. соёл, урлагийг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ;

6.1.4.4. нийгмийн хамгааллын бодлого, арга хэмжээ;

6.1.4.5. хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах, ядуурлыг бууруулах бодлого, арга хэмжээ.

6.1.5. засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын хөгжил, бодлого, арга хэмжээ:

6.1.5.1. төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, иргэдийн оролцоог хангах, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээ, хүний эрх, эрх чөлөөг хангах, сайжруулах бодлого, арга хэмжээ;

6.1.5.2. нийгмийн дэг журмыг сахиулах, гэмт хэргийг бууруулах бодлого, арга хэмжээ;

6.1.5.3. хэвлэл мэдээллийг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ;

6.1.5.4. хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэл, шүүх засаглалыг сайжруулах бодлого, арга хэмжээ;

6.1.5.5. олон тулгуурт гадаад бодлогыг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ;

6.1.5.6. батлан хамгаалах, хил хамгаалалт, иргэний хамгаалалтын салбар хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ.

## Долоо. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах

7.1. Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлуулан, албан ёсоор хэвлэснээс хойш 14 хоногийн дотор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.2. Жил бүрийн Үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар баталсны дараа аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг тогтоосон бүтэц агуулгад нийцүүлэн тухайн оны төсвийн хамт

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлан хэрэгжүүлнэ.

7.3. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээ, хөгжлийн үзүүлэлтийг ханган ажиллана.

7.4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг улирал бүрийн дараа сарын 25-ны дотор гарган санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

7.5. Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар гаргаж, Засгийн газарт танилцуулна.

7.6. Засгийн газраас Үндсэн чиглэлийн биелэлтийн жилийн эцсийн дүнг дараа оны 1 дүгээр улиралд багтаан гаргаж, Улсын Их Хуралд танилцуулна.

7.7. Улсын Их Хурал жил бүрийн үндсэн чиглэлийн нэгдсэн дүнд үндэслэсэн Засгийн газрын бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг Улсын Их Хурлын сонгууль зарлахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө олон нийтэд мэдээлнэ.

7.8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас Үндсэн чиглэлд тусгасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх явцад гарсан хүндрэлтэй асуудлыг судлан шийдвэрлэх арга замын талаар асуудал боловсруулан Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж болно.

7.9. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх явцад бодит нөхцөл байдлын улмаас тасарч болох болон хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй асуудлуудаар Засгийн газар санал боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлж болно.

## Найм. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

8.1. Журам зөрчсөн төрийн албан хаагчид Төрийн албаны хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Зарим тусгай хамгаалалттай газрын хилийн заагийг өөрчлөх тухай тогтоолын төслийг буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Ашигт малтмалын тухай болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хооронд нь уялдуулах замаар тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн заагаас улсын хил орчмын зурвас газрыг ашигт малтмал хайх, ашиглах зорилгоор гаргах, тусгай хамгаалалттай газарт байгаль орчны хяналтын тусгай горимын дагуу ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа явуулах газрыг нарийвчлан

тодотгох боломжийг болон тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх талаар орон нутгийн саналыг судалсны эцэст нэг мөр шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Зарим тусгай хамгаалалттай газрын хилийн заагийг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох тухай**

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27-дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Цэрэнсономын Аюурзаныг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаар, Самбуугийн

Дэмбэрэл, Дэмчигжавын Моломжамц, Дуламсүрэнгийн Нямаа, Жигжидийн Үнэнбат, Чимидийн Энхбаатар нарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Тэтгэвэр нь түр зогсоогдсон иргэдийн авч байгаа нөхөн олговрын доод хэмжээг сард 32000 төгрөгөөр тогтоож, 2004 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 67 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

### Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 3.3 дахь заалт, ил санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ш.Гунгаадорж, Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн

Т.Ганди, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Н.Баяртсайхан, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Шаравдорж, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Т.Очирхүү нарыг тус тус сонгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

### 2004 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Байнгын хороодоос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2004 оны хаврын ээлжит чуулганаар хууль тогтоомжид хугацаа зааж хэлэлцэхээр тогтоон болон бодлогын шинжтэй гэж үзсэн дараахь асуудлыг хэлэлцүүлсүгэй:

1/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

2/ Усны тухай багц хуулийн төсөл;  
3/ Байгаль орчны багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

4/ Тариалангийн тухай хуулийн төсөл;

5/ 2005 оны төсвийн хүрээний мэдэгдэл;

6/ Монгол Улсын 2003 оны төсвийн гүйцэтгэл;

7/ Чингис хааны нэрийг хэрэглэх тухай хуулийн төсөл;  
8/ бусад.

2. Улсын Их Хурлын ээлжит чуулганы хэлэлцүүлгийн шатанд байгаа төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцүүлсүгэй.

3. Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр төсөл санаачлагчдаас санал болгосон болон шаардлагатай гэж үзсэн бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг 2004 оны 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлбэл энэ оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4. Улсын Их Хурлын 2004 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нар болон Тамгын газар /Н.Пувсанжав/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2.5